

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Тооллогын комиссын тогтоол, хурлаас гарах
шийдвэрүүдийг батлах тухай

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тогтоолыг баталсугай.
2. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тогтоолыг үндэслэн хурлаас гарах шийдвэрүүдийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн 95.4 хувийн саналаар удирдах зөвлөлөөс өгөх дүгнэлтийг батлав.
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгов. Үүнд:

Ердийн гишүүнээр:

а) Жамбаагийн Чимэдцэрэнг	1,124,043	саналын эрхээр
б) Ганхуягийн Оюунгэрэлийг	1,124,043	саналын эрхээр
в) Лутаагийн Буянбатыг	845,048	саналын эрхээр
г) Лутаагийн Энхнасанг	844,632	саналын эрхээр
д) Даваадашийн Минжмааг	844,625	саналын эрхээр
е) Гантулгын Төгөлдөрийг	827,047	саналын эрхээр

Хараат бус гишүүнээр:

ж) Базаррагчаагийн Сийлэгмааг	1,124,143	саналын эрхээр
з) Сахъяагийн Итгэлийг	687,411	саналын эрхээр
и) Лувсансамбуугийн Дашмягмаржавыг	687,203	саналын эрхээр



- 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай. Үүнд:
- | | | | |
|--|------|--------|-----------------|
| а) Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын сарын цалингийн хэмжээг 8,000,000 төгрөгөөр; | 95.4 | хувийн | саналаар батлав |
| б) Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний сарын цалингийн хэмжээг 1,000,000 төгрөгөөр; | 95.4 | хувийн | саналаар батлав |
| б) Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сарын цалингийн хэмжээг 1,200,000 төгрөгөөр; | 95.4 | хувийн | саналаар батлав |
| в) Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын сарын цалингийн хэмжээг 2,000,000 төгрөгөөр; | 95.4 | хувийн | саналаар батлав |
- 2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргад олгох жилийн мөнгөн урамшууллын хэмжээг компанийн 2024 оны жилийн нийт орлогын 2.0 хүртэл хувиар;
- 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын жилийн зардлын төсөв (цалин, урамшууллыг оролцуулахгүйгээр)-ийг 9,400,000 төгрөгөөр;

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

Тахько (ХК) компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Тооллогын комиссын
2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгөх дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлтэд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж ажиллахыг
шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсоныг баталж,
бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, Компанийн дүрмийн 7.2.4 дэх заалт, Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Дор дурдсан хүмүүсийг Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталж, тэдгээрийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй. Үүнд:

Ердийн гишүүнээр:

Лутаагийн Буянбат
Даваадашийн Минжмаа
Ганхуягийн Оюунгэрэл
Гантулгын Төгөлдөр
Жамбаагийн Чимэдцэрэн
Лутаагийн Энхнасан

Хараат бус гишүүнээр:

Лувсансамбуугийн Дашмягмаржав
Сахъяагийн Итгэл
Базаррагчаагийн Сийлэгмаа

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын сарын цалин, жилийн мөнгөн урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлыг батлах тухай

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын сарын цалингийн хэмжээг 8,000,000 төгрөгөөр, ердийн гишүүний сарын цалингийн хэмжээг 1,000,000 төгрөгөөр, хараат бус гишүүний сарын цалингийн хэмжээг 1,200,000 төгрөгөөр, нарийн бичгийн даргын сарын цалингийн хэмжээг 2,000,000 төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргад олгох жилийн мөнгөн урамшууллын хэмжээг компанийн 2024 оны жилийн нийт орлогын 2.0 хүртэл хувиар тогтоосугай.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын зардлын төсөв (цалин, урамшууллыг оролцуулахгүйгээр)-ийг 9,400,000 төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ